



## УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- ✓ Авлигын эсрэг стратеги боловсруулж, хэлэлцүүлгийг орон даяар иргэд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, хэвийн хэвшил, төрийн байгууллагуудад **74** удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлэгт нийтдээ **3160** оролцогч хамрагдсан байна. Давхардсан тоогоор **4000** гаруй санал гарсаныг нэгтгэж байна. 1 сарын 10 үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулна.
- ✓ Иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хүндрэл чирэгдэл учруулсан, хууль бус төлбөр тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг судлах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд Баянзүрх, Чингэлтэй дүүрэгт болон Өмнөговь аймагт зарим тушаал шийдвэрийг хүчингүй болгуулах ажлыг эхлүүлээд байна.
- ✓ Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2013 онд нийт **5** зөвлөмжийг төрийн **306** (давхардсан тоогоор) байгууллагад хүргүүлжээ.
- ✓ Хүүхэд залууст шударга зан төлөв, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяныг нийслэлийн хэмжээнд зохион байгуулав. Тус аяны хүрээнд 6 багц арга хэмжээ зохион байгуулж 7200 сурагч, **4500** оюутан нийт **11700** залуучуудыг хамруулсан.
- ✓ **141** байгууллагын **26257** хүн, 21 аймгийн **7000** гаруй хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан. Давхардсан тоогоор **33 мянга** гаруй хүнд авлига, ашиг сонирхлын зөрчлийн хууль тогтоомжийг сурталчлах ажлыг хийжээ.

## МӨРДӨН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР:

- ✓ 2013 онд Мөрдөн шалгах хэлтэст **970** гомдол, мэдээлэл хүлээн авснаас “Гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл”-д гэмт хэргийн шинжтэй **422** гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь 2012 оны мөн үетэй харьцуулахад **18.2 хувиар** өссөн.
- ✓ Урьд оны үлдэгдэл 5 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан **422** нийт **427** гомдол, мэдээллийг шалгаж **58** гомдол, мэдээлэл буюу **13.5** хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, **176** гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргаж **152** гомдол, мэдээлэл харьяаллын дагуу шилжүүлж, 6 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэг болон гомдол мэдээлэлд нэгтгэж шийдвэрлэсэн.
- ✓ Мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргүүдээс 43 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, **41** хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 30 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 21 хэргийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, **13** хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийг үндэслэн түдгэлзүүлж шийдвэрлэсэн.
- ✓ Эрүүгийн хэрэгт нийт 400 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад **36.5 хувиар** өссөн байх бөгөөд холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн **35** буюу **8.7 хувь**, төрийн захиргааны **85** буюу **21.2 хувь**, төрийн тусгай **46** буюу **11.5 хувь**, төрийн үйлчилгээний **42** буюу **10.5 хувь**, энгийн буюу аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан **192** буюу **48 хувийг** эзэлжээ.

## МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ИНДЕКСИЙН ДҮН ГАРАВ

- ❖ Монгол Улсын авлигын индекс 2013 оны байдлаар 0,65 гарсан нь 2011 оныхоос 0,02 пунктээр өссөн эерэг дүнтэй байна.
- ❖ Өөрөөр хэлбэл, Монгол Улс дахь авлигын түвшин өмнөх 2 жилийнхээс буурсан болохыг энэ удаагийн индекс харууллаа.

## ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС 85 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХОХИРОЛ УЧИРЧЭЭ

- ❖ Мөрдөн шалгасан нийт эрүүгийн хэргийн учруулсан хохирол **85 тэрбум** төгрөг болж байгаа нь өмнөх оноос **44.7 хувиар** өсчээ.
- ❖ Мөрдөн байцаалтын явцад **6.3 тэрбум** төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос **50.7 хувиар** өссөн, **17.1 тэрбум** төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан нь өмнөх оноос **77.1 хувиар** өссөн байна.

## ШҮҮХ 26 ШҮҮГДЭГЧИЙГ ГЭМ БУРУУТАЙД ТООЦОВ


- ❖ Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн **33** шүүгдэгчид холбогдох **11 хэрэг** шүүхээр шийдвэрлэгдэж **26** шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон **12** шүүгдэгчийг хорих ялаар, **5** шүүгдэгчийг торгох ялаар, **1** шүүгдэгчийг баривчлах ялаар, **2** шүүгдэгчийг тодорхой ажил, албан тушаал эрхлэх нэмэгдэл ялаар шийтгэж, хорих ял оногдуулсан **8** шүүгдэгчийн ялыг тэнссэн.
- ❖ Харин **7** шүүгдэгчид холбогдох **2** хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

- ✓ 2013 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн **10400** гаруй этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, хариуг хүргүүлсэн бөгөөд **2800** албан тушаалтанд анхааруулга өгч, илт ашиг сонирхлын зөрчлийн улмаас томилох боломжгүй **52** дүгнэлтийг хүргүүлж, мэдүүлгийг хянуулалгүй хууль зөрчин томилсон **320** гаруй шийдвэрийг хүчингүй болгов.
- ✓ Ашиг сонирхлын зөрчил, мэдүүлгийн асуудлаар АТГ-т ирсэн гомдол, мэдээллийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад **1,1 дахин** өссөн үзүүлэлттэй байна.
- ✓ 2013 онд Авлигын эсрэг хууль тогтоомж, ХАСХОМ мэдүүлэх асуудлаар 200 орчим байгууллагын **1436** эрх бүхий албан тушаалтан, **9531** мэдүүлэг гаргагч, нийт **10967** албан тушаалтанд сургалт зохион байгуулж, 5 төрлийн гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, нийтийн хүртээл болгов.
- ✓ 2013 онд шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтныг сургаж, мэргэшүүлэх зорилгоор “ЭБАТ-ТАЙ ЯРИЛЦАХ ЦАГ” уулзалтыг 7 хоног тутамд тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн бөгөөд энэхүү сургалтад нийслэл дэх нийт эрх бүхий албан тушаалтнуудын **85** орчим хувийг хамруулав.
- ✓ 2013 онд **20** аймагт ажиллаж, аймгийн ИТХ, ЗДТГ-ын ЭБАТ-ны ажилтай танилцан, холбогдох зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласнаас гадна орон нутгийн мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад ХАСХОМ мэдүүлэх асуудлаар сургалт зохион байгуулж ажилласан.

## Хяналт шалгалтын чиглэлээр ирсэн өргөдөл, гомдлын агуулга

хувиар



## МЭДҮҮЛГИЙН ЦАХИМ СИСТЕМ НЭВТРҮҮЛСЭН

- ❖ [www.meduuleg.iaac.mn](http://www.meduuleg.iaac.mn) сайтад **1500** орчим салбар нэгжийн **47000** гаруй мэдүүлэг гаргагчдын мэдүүлгийн талаарх мэдээллийн нэгдсэн сантай болов.
- ❖ [www.xacxom.iaac.mn](http://www.xacxom.iaac.mn) цахим хуудсанд **239** албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуйг маягтын дагуу бэлтгэж олон нийтэд нээлттэй танилцуулах боломжийг хангав.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХАРИУЦЛАГА ТООЦСОН:

- Хяналт шалгалтын чиглэлээр нийт **255** албан тушаалтанд хариуцлага тооцуулснаас ажлаас халсан 26, албан тушаал бууруулсан 22, албан тушаалын цалинг 3 хүртэл сарын хугацаанд 30 хувиар бууруулсан 94, сануулсан 95, бусад арга хэмжээ авсан 18 байна.
- Хариуцлага тооцуулсан **255** албан тушаалтны **43** хувь буюу 110 нь ХАСМХОМ-ийн, **18** хувь буюу 45 нь өргөдөл, гомдлын, **39** хувь буюу 100 нь мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар тус тус хариуцлага тооцуулсан.

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлого мэдүүлгийн хяналт шалгалтыг эрчимжүүлэв.

- 2013 онд нийт **557** албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаар хүлээн авснаас **533**-ыг шалгаж дууссан бөгөөд **24** албан тушаалтны мэдүүлгийг шалгах ажил үргэлжилж байна.
- Нийт мэдүүлгийн **363** нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар, **98** нь иргэд, байгууллагын гомдол, мэдээллээр, **96** нь тус газрын МШХ-ийн хүсэлтээр тус тус шалгуулахаар бүртгэгдсэн байна.

№	2013 онд хариуцлага тооцуулсан байдлыг хяналт шалгалтын төрөл, хариуцлагын хэлбэр, албан тушаалтны харьяаллаар нь үзүүлбэл:	Сануулсан	Цалинг бууруулсан	Албан тушаал бууруулсан	Ажлаас халсан	Бусад	Бүгд	Эзлэх хувь
1.	Мэдүүлгийн хяналт шалгалтаар	25	61	11	13		<b>110</b>	43%
2.	Өргөдөл, гомдлын хяналт шалгалтаар	5	20	6	10	4	<b>45</b>	18%
3.	<u>Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар</u>	65	13	5	3	14	<b>100</b>	39%
	<u>Нийт дүн</u>	<b>95</b>	<b>94</b>	<b>22</b>	<b>26</b>	<b>18</b>	<b>255</b>	<b>100%</b>
Үүнээс:	<u>УБ хот дахь байгууллагын албан тушаалтан</u>	59	74	14	16	3	<b>166</b>	65%
	<u>Орон нутаг дахь байгууллагын албан тушаалтан</u>	36	20	8	10	15	<b>89</b>	35%

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР  
5-р хороолол, Сөүлийн гудамж 41  
Улаанбаатар хот 14250

УТАС: 7011-2463  
ФАКС: (976)-70112458  
ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ  
УТАС:  
1969 /Энгийн утасны тариф/



ШУДАРГА НИЙГМИЙН ТӨЛӨӨ  
ХАМТДАА

ХҮҮХЭД ЗАЛУУСЫН ХӨДӨЛГӨӨН  
WWW.XAMTDAА.MN